



## Үндэсний виз мэдүүлэх заавар

### Сайн дурын ажил эрхлэх виз (BFD, FSJ, FÖJ, EFD)

#### Ерөнхий заавар

- Гэрчилгээ, Диплом болон бусад баримт бичгийн эх хувийг өгнө. Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа эх хувийг буцаан олгоно.
- Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэхийн тулд Герман дахь Холбооны Хөдөлмөрийн Товчоо болон Гадаадын Харьяат Иргэдийн газрын зөвшөөрөл авдаг. Тус газраас зөвшөөрөл ирсний дараа виз олгох боломжтой.
- Визийн мэдүүлгийг дунджаар ажлын 10 хоногт шийдвэрлэнэ. Зарим тохиолдолд илүү хугацаа орж болно.
- Визийн мэдүүлгийг өгөхдөө нислэгийн тийзийн захиалга өгөх шаардлагагүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх явцад ЭСЯ-наас нэмэлт бичиг баримт шаардаж болно.
- Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх нь шийдвэрлэх хугацааг уртасгах бөгөөд цаашлаад татгалзах эрсдэлтэй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх ажлын 10 хоног дотор утсаар болон И-Мэйлээр лавлан асуух шаардлагагүй. Энэ нь визийн хэлтсийн ачааллыг нэмэгдүүлэх тул виз мэдүүлэгч бүрт тухайлан хариулах боломжгүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэхэд олон хүчин зүйлс, нөхцөл байдлыг харгалзан шалгах учраас зааврын дагуу бичиг баримтаа бүрэн бүрдүүлж өгөх нь виз гарах баталгаа биш.
- Маягтыг визийн хэлтсээс үнэ төлбөргүй авах боломжтой. Виз мэдүүлэхэд үйлчилгээний хураамж төлөх бөгөөд тухайн хураамжийг виз татгалзсан, мэдүүлгээ буцаан авсан аль ч тохиолдолд эргүүлэн олгохгүй.
- Виз мэдүүлэх бичиг баримт бүрдүүлэхдээ ямар нэгэн байгууллага эсвэл гуравдагч этгээдийн туслалцаа, үйлчилгээг ашиглах шаардлагагүй. Өгсөн мэдүүлгийн хариуцлага, үр дагаврыг зөвхөн виз мэдүүлэгч өөрөө хариуцна.
- Виз мэдүүлэгч нь ЭСЯ-ны Консулын хэлтэст биечлэн ирж бичиг баримтаа өгнө.



### Ерөнхий мэдээлэл

Бүх нийтийн сайн сайхны төлөөх үйлсэд идэвхтэй оролцож өөрийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд сайн дурын албанд ажиллах эрхэм зорилго оршино.

Холбооны Сайн Дурын Алба (Bundesfreiwilligendienst) эсвэл Залуучуудын Сайн Дурын Албыг (Jugendfreiwilligendienst) Германд хийх сонирхолтой бол виз мэдүүлэх ёстой. Германд сайн дурын алба хаах нь хөдөлмөр эрхлэлт гэж тооцогдох бөгөөд Европын Сайн дурын албаны (Europäische Freiwilligendienst) хүрээнд ажиллах бол Германы Оршин суух тухай хуулийн 19-е зүйлээр (§19e AufenthG), Сайн Дурын Экологийн жил (Freiwilliges Ökologisches Jahr - FÖJ), Сайн Дурын Нийгмийн жил (Freiwilliges Soziales Jahr - FSJ)-ийн хүрээнд ажиллах визийн мэдүүлгийг Оршин суух тухай хуулийн 19-с зүйлийн 1 болон Хөдөлмөр эрхлэх тухай зохицуулалтын 14-р зүйлийн 1 (§19c Abs. 1 AufenthG i.V.m. § 14 Abs. 1 Nr. 1 BeschV)-ийн дагуу шийдвэрлэнэ. Сайн дурын албаны төрлөөс хамаарч насны хязгаар нь ялгаатай:

**FSJ/FÖJ (Freiwilliges Soziales Jahr / Freiwilliges Ökologisches Jahr)**-ны хүрээнд ажиллах бол виз мэдүүлэх өдөр 27 нас хүрээгүй байх ёстой. Weltwärts болон Süd-Nord хөтөлбөрт хамрагдаж байгаа бол 29 настай ажиллаж болно. BFD (Bundesfreiwilligendienst) бол насны хязгаар байдаггүй. EFD –Европын Сайн дурын албанд ажиллаж эхлэхдээ 17 нас хүрсэн байх бөгөөд алба хаах газарт хүсэлтээ илгээхдээ 30 нас хүрээгүй байх ёстой.

**Bundesfreiwilligendienst** – визийн мэдүүлэг:

Холбооны Гэр бүлийн болон Иргэний нийгмийн асуудал эрхлэх газрын (BAFzA) болон ажиллах гэж байгаа газрын, шаардлагатай бол эрх бүхий хариуцагч байгууллагын болон виз мэдүүлэгч нар гарын үсгээ зурсан гэрээ.

**Jugendfreiwilligendienst (FSJ und FÖJ)** – визийн мэдүүлэг:

Ажиллах гэж байгаа газрын, шаардлагатай бол эрх бүхий хариуцагч байгууллагын болон виз мэдүүлэгч нар гарын үсгээ зурсан гэрээ.

Виз мэдүүлэгч нь ЭСЯ-ны Консулын хэлтэст биечлэн ирж бичиг баримтаа өгнө. 18 нас хүрээгүй виз мэдүүлэгч асран хамгаалах эрх бүхий хүмүүсийн хамт ирнэ. Эцэг эхийн аль нэг нь Германд амьдардаг бол нотариатаар баталгаажуулсан зөвшөөрлийг хавсаргана.



**Визийн мэдүүлэгт бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт**

Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтуудыг эх хувиас гадна 2 хувь хуулбарын хамт өгнө.  
Англиас бусад хэл дээрх бичиг баримтыг герман орчуулгын хамт өгнө.

Бичиг баримтаа доорх дарааллаар эрэмбэлнэ үү.

1	Бүрэн гүйцэд бөглөсөн, виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан үндэсний визийн маягт 2 хувь ("VIDEX" маягт).	<input type="checkbox"/>
2	Биометрийн шаардлага хангасан 35*45 мм хэмжээтэй 2 хувь цээж зурагны нэгийг үндэсний визийн маягтын цээж зураг байрлах хэсэгт нааж хоёр дахь зургийг нь наалгүй авч ирнэ.	
3	Хүчинтэй гадаад паспорт	
4	Гадаад паспорт эзэмшигчийн хувийн мэдээлэл бүхий нүүрний хуулбар	
5	Ямар зорилгоор нийгмийн сайн дурын ажил Германд хийх сонирхолтой байгаа талаар дэлгэрэнгүй тайлбар захидал (Motivationsschreiben)	
6	Өнөөг хүртэл эзэмшсэн мэргэжил, боловсрол ба эрхэлж байсан ажлаа алгасалгүй бүрэн оруулсан, хүснэгтчилсэн намтар	
7	Германд Сайн дурын алба хаах газартай байгуулсан гэрээ. Таны гэрээнд очоод байрлах хаяг болон амьжиргааг хэрхэн шийдвэрлэх тухай тодорхой тусгаагүй бол энэ талаарх нэмэлт баримт баталгаа. <ul style="list-style-type: none"> <li>➔ Холбооны Сайн Дурын Алба (BFD): Холбооны Гэр бүлийн ба Иргэний Харилцааны газар (BAFzA) болон холбогдох салбарыг хариуцсан газар, сайн дурын ажлыг хариуцагч (Träger) талууд гарын үсгээ зурсан гэрээ байх ёстой</li> <li>➔ Сайн Дурын Нийгмийн жил/Сайн Дурын Экологийн жил (FSJ/FÖJ): сайн дурын ажлыг хариуцагч (Träger) ба виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан гэрээ байх ёстой</li> <li>➔ Европын Сайн Дурын Алба (EFD): “Nationalen Agentur Erasmus + Jugend in Aktion” ба сайн дурын ажлыг хариуцах талууд гарын үсгээ зурсан гэрээ байх ёстой. Сайн дурын ажлын хүрээнд гүйцэтгэх ажил болон төлөвлөж байгаа сургалтын үр дүнгийн талаар тодорхой дурьдсан тохиролцоо (Vereinbarung) хариуцагч ба виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан гэрээ байх ёстой.</li> <li>➔ Холбооны Сайн Дурын, Сайн Дурын Нийгмийн, Сайн Дурын Экологийн жил (BFD/FSJ/FÖJ): ажиллах газар, хариуцагч байгууллагаас хэлний мэдлэг шаардлагагүй эсвэл ажиллаж эхэлснээс хойш хэлний курсэд сурч зохих түвшний хэлний мэдлэгтэй болно гэсэн баталгаа шаардана.</li> </ul>	
8	Байгаа бол: ALTE стандартын дагуу хэлний мэдлэгийг шалгах эрх бүхий байгууллагаас олгосон Герман хэлний сертификат. Das Deutsche Sprachdiplom (DSD) – Герман хэлний дипломыг мөн хүлээн зөвшөөрнө. Герман хэлний A1 түвшний мэдлэггүй бол эхний ээлжинд Герман хэлний анхан шатны мэдлэг шаардлагагүй Германд очсон даруйдаа хэлний дамжаанд сурч хэлээ сурах боломжтой тухай ажиллах газар / хариуцагч багйууллагаас авсан баталгаа.	
9	Нийт хугацааг хамарсан эрүүл мэндийн даатгал (Ажиллах байгууллага хариуцна)	

Энэхүү жагсаалтыг ЭСЯ тухайн цаг үеийн мэдлэг, дүгнэлт дээр үндэслэн гаргасан болно. Жагсаалтын бүрэн гүйцэд, үнэн зөв байдал ялангуяа цаг хугацааны хувьд гарч болох өөрчлөлтүүдийн өмнөөс ЭСЯ хариуцлага хүлээхгүй.



	Европын Холбооны журамд нийцсэн эрүүл мэндийн даатгал: ( Шенгений орнуудад болон Германд оршин суухад хүчин төгөлдөр үйлчлэх, багадаа 30.000 Евроны нөхөн төлбөртэй, Германд нэвтрэх өдрөөс эхлэн нийт оршин суух хугацаанд хүчинтэй), эрүүл мэндийн даатгалын баримтыг (хуулбарыг) визтэй паспортаа авахдаа ЭСЯ-нд өгнө.	
<b>Монголоос өөр орны иргэншилтэй виз мэдүүлэгч</b>		
10	Монгол Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл	
<b>Хураамж</b>		
11	Визийн хураамж 75 еврог монгол төгрөгөөр	
<b>Визийн мэдүүлгийн бүрэн гүйцэд байдал</b>		
Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт бүрэн гүйцэд байгаа эсэх:		
<input type="checkbox"/> тийм		
<input type="checkbox"/> үгүй, чагтлаагүй үлдсэн бичиг баримт/мэдээлэл дутуу		
<b>Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх тухай мэдэгдэл</b>		
Миний визийн мэдүүлэг бүрэн гүйцэд бус байгаа талаар надад мэдээлсэн. Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт дутуу байх нь визийг татгалзах эрсдэлтэй гэдгийг миний бие ойлгож байгаа бөгөөд визийн мэдүүлгээ өгөх хэвээр байгаа гэдгийг мэдэгдэж гарын үсгээ зурсан болно.		
_____ газар, огноо, гарын үсэг		